



НИЙСЛЭЛИЙН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗАР" ОНӨААТҮГ

"НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ

"АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛД ӨРТӨХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ НЭГТГЭСЭН ТАЙЛАН



2026 оны 05 дугаар сарын 26



Улаанбаатар хот



ҮНДЭСЛЭЛ

- ✓ Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)
- ✓ Газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/09 дугаар тушаалаар батлагдсан Ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
- ✓ Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны "Аргачлал батлах тухай" 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛД ӨРТӨХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС"-ын А, Б хэсгийг тус тусад нь линк үүсгэж, үнэлгээний хуудсыг бөглөх зааварчилгааг, мэдээллийг постер байдлаар бэлтгэн албан хаагч нарт танилцуулан, үнэлгээг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд авч, үр дүнг нэгтгэв.



ҮНЭЛГЭЭНД ХАМРАГДСАН БАЙДАЛ



Нийт ажилтан

96



Хамрагдсан ажилтан


76

ХАМРАГДАЛТ: 79%

ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН



Судалгааны А хэсэг: Албан хаагч өөрийн чиг үүргийн хүрээнд ажиллахад тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг тодорхойлох үнэлгээ



Эрсдэлийн түвшин

БАГА (1-5 оноо)


76 ажилтан
100%



Үнэлгээнд хамрагдсан 76 албан хаагч 100 хувь эрсдэлийн түвшин бага буюу 1-5 оноотой үнэлэгдсэн.



Судалгааны Б хэсэг: Байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, соёлын тухайд тохиолдож буй бэрхшээлийг тодорхойлох үнэлгээ



Эрсдэлийн түвшин

БАГА (1-5 оноо)

76 ажилтан
100%



Үнэлгээнд хамрагдсан 76 албан хаагч 100 хувь эрсдэлийн түвшин бага буюу 1-5 оноотой үнэлэгдсэн.



ДҮГНЭЛТ

Иймд Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны "Аргачлал батлах тухай" 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛД ӨРТӨХ ЭРСДЭЛИЙГ ТООЦОХ ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ"-ын дагуу үнэлгээнд хамрагдсан нийт албан хаагчид бага эрсдэлтэй үнэлэгдсэн тул шууд арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагагүй бөгөөд хяналтыг үргэлжүүлэн, холбогдох хууль тогтоомж, төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй гэж дүгнэлээ.



НЭМЭЛТ ДҮГНЭЛТ

Мөн газрын ажилтан, албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээнд нийт ажилтнуудыг бүрэн хамруулах, удирдах албан тушаалтнууд манлайлан үнэлгээнд оролцох, үнэлгээний асуумжийг бөглөх жишээ, зааварчилгааг ойлгомжтой байдлаар албан хаагч нарт мэдээлэл хүргэж үнэлгээг авах нь үнэлгээний үр дүн илүү үнэн бодитой гарч, эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой төлөвлөх боломжтой гэж дүгнэж байна.



Ажилтан, албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн, хэрэгжүүлэх.



Цаашид "Албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын дагуу үнэлгээг жил бүр тогтмол зохион байгуулж, үр дүнд үндэслэн үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлэх.



Үнэлгээнд газрын нийт ажилтан, албан хаагчид болон удирдах албан тушаалтнуудыг бүрэн хамруулах.



Үнэлгээний асуумжийг бөглөх жишээ, зааварчилгааг ойлгомжтой байдлаар албан хаагч нарт хүргэж, үнэлгээг илүү итгэлтэй, бодитой авах.